



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/610

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 2022 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж буй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуй газар (Т.Сүхбаатар)-т олгосугай.

2.Худгийн цооног гаргах ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй газар (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл) нарт тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ